

## Орхоны хөндийн БЦГ-ын

### Хамгаалалтын захиргааны 7 сарын мэдээ

2016 оны 7 сарын 29

Орхоны хөндийн БЦГ түүний орчны бүсийн бэлчээр хадлан сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны материал болон холбогдох судалгаануудыг гарган KFW төслийн судалгааны багт хүргүүлээ.

Монгол улс дахь нутгийн иргэдэд түшиглэсэн намаг хамгаалах. Ашиглах стратеги семинарт хамгаалалтын захиргааны дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар оролцлоо.

Хархорин сумын Орхон багийн Баянзүрх, Нарийн, Урт, Хотонт сумын Тэмээн хүзүү зэрэг газруудаар явж нутгийн айл өрхүүдтэй уулзаж байгалийн дагалт баялагийг зүй зохистой ашиглах талаар ярилцаж хамтран ажиллахаар тохиролцлоо.

Хамгаалалтын захиргаа Хархорин сумын Сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран Хархорин сумын Мойлтын рашааныг хашиж хамгааллаа.





Хархорин сум үүсэн байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн баяр наадмын арга хэмжээнд Орхоны хөндийн БЦГ-ын дэргэдэх Орхон эко клуб "Цэвэр орчинд цэмцгэр наадъя" арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

“6 ш ус ундааны савыг 1 сугалаагаар урамшуулан авч байна” гэж зарлахад наадамчдын хүүхдүүд олноор ирж дахин ашиглагдах хогоо тушааж эко клубын хүүхдүүд ачаалал ихтэй ажилласан.

Мөн “Наадмын талбайд байрлуулсан хогийн саванд барьсан хогоо хаяж эко клубын хүүхдүүдийг дэмжиж наадаарай” хэмээн ухуулан сурталчиллаа. Наадмын эхний өдөр 80 уут хог, 3 шуудай /гахай/ ундааны сав, дараагийн өдөр 100 уут хог, 6 шуудай /гахай/ ус ундааны сав нийт 1 машин хог ачуулж, 4000 гаруй ус, ундааны сав буюу 90 кг сав хурааж 1кг-ыг 100 төгрөгөөр тушаасан.



Хамгаалалтын захиргааны албан хаагчид байгууллагын хашаанаас засмал зам хүртэл 200 м хүртэл газар хамгаалалтын шон татах, байгууллагын хашаан доторх явган хүний замын засвар, тохижилт, захиргааны барилгыг гадна талыг будаж сэргээх, хашааны хаалгануудын шинэчилэх ажлуудыг өөрсдийн хүч, нөөц бололцоог ашиглан хийж гүйцэтгэн түүхт ойн баяраа угтлаа.



Орхоны хөндийн БЦГ 20 жилийн ойн баяраа 7 сарын 21 ний өдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Ойн баярын хөтөлбөрийн дагуу Гэрэлт хөшөөний нээлтийн ёслол, Баярын хурал хүндэтгэлийн арга хэмжээ, шагнал гардуулах ёслол, Баярын концерт, "Орхоны хөндий байгаль, түүх соёлын өлгий нутаг" эрдэм шинжилгээний бага хурал, хүндэтгэлийн хүлээн авалтыг амжилттай зохион байгууллаа. Ойн арга хэмжээнд ОХБЦГ-ын үүсгэн байгуулагчид, үе үеийн удирдлагууд, албан хаагчид, эрдэмтэн судлаачид, харъяа сумдын удирдлагууд, хамтран ажилладаг ААН, байгууллагуудын төлөөлөл, нөхөрлөл бүлгүүдийн гишүүд нийт 140 гаруй хүн уригдан, хүрэлцэн ирж оролцлоо.



Хамгаалалтын захиргаанаас тус захиргааг үүсэн байгуулахад хувь нэмрээ оруулсан 2004-2008 онд Өвөрхангай аймгийн Засаг дарга байсан Б. Эрдэнэбилэгт, ХНБЦГ-ын анхны дарга байсан Г. Зундуй, Хамгаалалтын захиргааны дарга байсан Д. Баярмаа нарт хүндэтгэл үзүүлэн алд цэнхэр хадаг мөнгөн аяга, идээний дээжийг өргөн барилаа.



Ойн баярын үеэр Хамгаалалтын захиргааны дарга Г. Эрдэнэбилэг, АЖМС хариуцсан мэргэжилтэн Ч. Суурьтогтох нар Аялал жуулчлалын тэргүүний ажилтан цол тэмдгээр, БНМ хариуцсан Ахлах мэргэжилтэн Р. Амартүвшин, байгаль хамгаалагч Д. Дүгэрдорж, Б.Даш, Б. Анхбаяр, Ахмад ажилтан Б.Равдансүрэн нар Байгаль орчны тэргүүний ажилтан, ня-бо Р. Хэнчбиш БОНХАЖ Яамны Хүндэт жуух бичиг, Байгаль хамгаалагч Ш.Баасансүрэн, Х.Чулуунбат, жолооч С.Мөнхбаяр нар МЗХ-ны Хөдөлмөрийн алдар медаль, Ж.Үүрцайх, Ж. Мягмаржав, А.Баярмагнай, М.Батбаатар нар ҮЭ-ийн нэрэмжит шагнал, байгаль хамгаалагч Ш.Мөнхсайхан, архив, бичиг хэргийн эрхлэгч И.Мөнхзул нар Засаг даргын жуух бичгээр шагнагдлаа.



“Орхоны хөндийн байгаль түүхий өлгий нутаг” эрдэм шинжилгээий бага хурал амжилттай болж дараах илтгэлүүд тавигдлаа.

1 С. Шийрэв-Адъяа-ШУА-ын Газарзүй Гео экологийн хүрээлэнгийн ЭШ-ний тэргүүлэх ажилтан Доктор дэд профессор Орхоны хөндийн Нүүдлийн МАА-н бэлчээр ашиглалтын өлгий ба өнөө үе дэх өөрчлөлт

2 Н.Баатарбилэг,- МУИС-ын Хэрэглээний ШУ, Инженерчлэлийн сургуулийн захирал доктор, профессор Их эзэнт гүрний үеийн уур амьсгалын түүх, Монголчууд хүчирхэг байхад уур амьсгалын үзүүлсэн нөлөө

3 Ч.Сономдагва - МУИС-ын Хэрэглээний ШУ, Инженерчлэлийн сургууль, Хүрээлэн буй орчин судлалын профессорын баг Хархорин сум орчмын Орхоны хөндийн хөрсний судалгаа

4 Ч.Жавзан- ШУАкадеми, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн ЭШАА, доктор Орхон голын савын эхэн хэсгийн рашааны судалгаа

5. Орхон гол түүний цутгалуудын усны чанарын судалгаа

6. Н.Сарангарав- ХААИСургууль, Агроэкологийн сургуулийн багш, судлаачдын баг Орхоны хөндийн байгалийн цогцолборт газарт тогтвортой хөгжлийн чиг хандлага бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал

7 Ц. Бямба-Эрдэнэ БХИС-ын батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, Цэргийн түүх судлалын төв ЭШАжилтан Харбалгас хотын археологийн судалгаа

8 Ж. Цамбагарав Хархорум музейн ЭШАжилтан Орхоны хөндийн соёлын дурсгалт газар дахь Хорхорум музей

9.Р. Амартүвшин - Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны БНМ хариуцсан Ахлах мэргэжилтэн Орхоны хөндийн БЦГ-ын гамшгийн эмзэг байдал, эрсдлийн үнэлгээ, судалгаа

10 Ж. Пүрэв - Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны СШМС хариуцсан мэргэжилтэн ОХБДГ- хийсэн Янгир ямааны судалгаа

11 Д. Эрдэнэчимэг- Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны ХХХШ хариуцсан мэргэжилтэн ОХБЦГ Ургамалжилтын судалгаа Хархорин сумын жишээн дээр

12 Ч.Догсом- Дэлхийн өв-Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн Соёлын өвд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийн судалгаа

13 Ч. Суурьтогтох - Орхоны хөндийн БЦГ-ын Хамгаалалтын захиргааны АЖМС хариуцсан мэргэжилтэн Орхоны хөндий дэх аялал жуулчлалын өнөө ба ирээдүй илтгэлүүд тавигдаж арга хэмжээнд хүрэлцэн ирсэн мэргэжил нэгт хүмүүсийн талархалыг хүлээсэн.



Баяр наадмын өдрүүдээр хамгаалалтын захиргаа, сумын засаг даргатай хамтарсан удирдамж гарган байгаль хамгаалагчид хүч нэмэгдүүлэн ажиллаж аялагч жуулчдад

тусгай хамгаалалттай газар нутгийн талаар мэдээлэл сурталчилгаа хийн, ажилтан, албан хаагчид хүч нэмэгдүүлэн ажиллаж Орхон голын эрэг дагуух болон Отоглох цэгүүдийн хог хаягдлыг сумын ЗДТГ, Цэвэр Орхон бүлэгтэй хамтран цэвэрлэж хоггүй наадлаа.

Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн Ч.Суурьтогтох